



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АРВАНТАВДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 13

Мөрөн сум

**"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний
тайлан хэлэлцсэн тухай**

Монгол улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын арвантавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол улсын хэмжээнд хэрэгжиж буй "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр болон Хэнтий аймгийн "Гучин сая мод" хөтөлбөрийг хэрэгжүүлж Мөрөн суманд 2023 онд 13920 мод тарьж хөтөлбөрийн хэрэгжилт 92,7 %-тай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсүгэй.
2. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх сангийн зардлыг жил бүр төлөвлөж, төсөвт тусгахыг Сумын Засаг дарга /Ц.Батцроож/-д даалгасугай.

ДАРГА

Д.ЭНХСҮХ

